



**“ХҮННҮ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 20

№: А/02

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, “Хүннү менежмент” ХК (цаашид “Сан” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 10-р зүйлийн 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2024 оны 04 сарын 30-ны өдрийн 15:00** цагаас Улаанбаатар хот, Самбуугийн гудамж, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, MN tower, 8 давхар, 810 тоотод хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. үүнд:
  - 1.1.Компанийн 2023 үйл ажиллагааны тайлан танилцуулах;
  - 1.2.Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
  - 1.3.Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - 1.4.ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлж тэдгээрийн оронд шинэ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд сонгох;
  - 1.5.Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх;
  - 1.6.Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **хавсралт №1**-ээр, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **хавсралт №2**-оор, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **хавсралт №3**-аар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **хавсралт №4**-р, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **хавсралт №5**-р, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг **хавсралт №6**-р тус тус баталсугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2024 оны 04 сарын 11-ний өдрөөр** тогтоосугай.
5. Хурлын зарыг **2024 оны 03 сарын 25, 2024 оны 04 сарын 17-ны өдрүүдэд** хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь **2024 оны 04-р сарын 29-ны өдрийн 16 цаг 00 минут** хүртэл байна.

7. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан **2024 оны 03-р сарын 22-ны** өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын **Хавсралт №1** болон **Хавсралт №2** дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-г заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр **2024 оны 03-р сарын 28-ны** өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга ... овогтой Тулгабатыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх, хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийнхуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх, санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийнсанал өгөх эрхийг хангах, саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх, саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийнхуралд танилцуулах, саналын хуудсыг Компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэхийг тус тус үүрэг болгосугай.
  - 10.1. Комиссын дарга: Б.Тэргэл;
  - 10.2. Гишүүд: Б.Ган-Эрдэнэ;  
Б.Сугар-Эрдэнэ;
11. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТЖАРГАЛ